# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

## Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГСА-2024/64/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2024 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудитХХК-ийн
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069
Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com
Чанарын менежер: Г.Цогтбаатар
Аудитор: Н.Цэнгэнбаяр

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 10
**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ... 11
5.1 Төлбөрийн акт ... 11
5.1.1 Бараа материалтай холбоотой асуудал ... 11
5.2 Албан шаардлага ... 11
5.3 Зөвлөмж ... 12
**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ... 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.02.23 № 39
танай ____________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Г.СОНИНБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

0080203

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг хэрэгжүүлж 92.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг сумын Засаг даргын үнэлгээ гараагүй бөгөөд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар 76.7 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/ төгрөгөөр /*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **218,305,331.75** | **329,620,435.99** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3,363,774.07 | 122,400,730.18 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **3,363,774.07** | **122,400,730.18** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 3,363,774.07 | 122,400,730.18 |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **13,750.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 13,750.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **214,941,557.68** | **207,205,955.81** |
| **351** | **Түүхий эд материал** | **403,300.00** | **220,800.00** |
| 35130 | Эм боох материал | 403,300.00 | 220,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **214,538,257.68** | **206,985,155.81** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,025,800.00 | 1,228,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 121,846,483.43 | 114,275,363.83 |
| 35450 | Барилгын засварын материал | 415,500.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 11,835,475.00 | 4,640,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 78,414,999.25 | 86,840,891.98 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,659,174,022.60** | **1,753,303,592.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,659,174,022.60 | 1,753,303,592.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,450,748,262.60** | **1,545,817,484.93** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,424,685,337.86 | 1,424,685,337.86 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (181,516,822.62) | (235,411,201.62) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 235,573,251.90 | 454,125,067.87 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (83,823,944.17) | (170,207,540.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 120,967,793.66 | 167,845,059.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (79,630,150.52) | (103,223,710.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 37,019,077.60 | 37,019,077.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (22,526,281.11) | (29,014,605.32) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **208,425,760.00** | **207,486,108.04** |
| 39301 | Програм хангамж | 3,798,260.00 | 3,798,260.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (407,500.00) | (1,347,151.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 205,035,000.00 | 205,035,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,877,479,354.35** | **2,082,924,028.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **2,038,500.00** |
| **413** | **Өглөг** | 0.00 | 2,038,500.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 2,038,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,877,479,354.35** | **2,080,885,528.96** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 631,596,249.02 | 631,596,249.02 |
|  | Дахин үнэлгээний нөөц | 777,203,112.87 | 777,203,112.87 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **468,679,992.46** | **672,086,167.07** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 468,679,992.46 | 468,679,992.46 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 203,406,174.61 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,877,479,354.35** | **2,082,924,028.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/ төгрөгөөр /*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,026,554,467.40** | **2,685,159,444.70** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **30,429,667.40** | **224,058,044.70** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 7,096,506.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,173,700.00 | 250,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 0.00 | 201,512,331.97 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал | 25,255,967.40 | 15,199,206.73 |
| **1311** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **6,981,800.00** | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,481,800.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **261,289,500.00** | **254,851,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 261,289,500.00 | 254,851,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,727,850,500.00** | **2,206,250,400.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,727,850,500.00 | 2,206,250,400.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,029,764,509.42** | **2,481,753,270.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,029,764,509.42** | **2,481,753,270.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,334,174,376.00 | 1,642,997,636.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,334,174,376.00 | 1,114,533,166.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 459,187,681.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 31,551,431.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 37,725,358.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **163,819,045.58** | **207,234,419.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 112,571,514.14 | 141,634,138.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,059,835.00 | 16,658,798.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,248,124.69 | 13,221,076.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,390,522.75 | 2,820,208.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,549,049.00 | 32,900,199.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **207,386,662.00** | **237,564,339.05** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,717,008.00 | 7,320,567.05 |
| 210302 | Түлш, халаалт | 180,526,500.00 | 190,154,580.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,143,154.00 | 40,089,192.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,383,465.17** | **52,925,933.60** |
| 210401 | Бичиг хэрэг | 12,610,737.00 | 21,849,789.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 918,843.00 | 452,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 384,111.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,481,800.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,957,974.17 | 6,279,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 24,344,244.60 |
| **2105** | **Нормативт зардал** | **118,805,915.26** | **113,205,266.20** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 858,830.00 | 613,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 117,947,085.26 | 112,591,566.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,121,387.00** | **8,705,200.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,121,387.00 | 8,705,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **160,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 160,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,058,000.00** | **19,280,794.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 738,000.00 | 7,096,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,320,000.00 | 12,184,294.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **155,828,152.82** | **192,021,120.60** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,389,013.00 | 20,540,609.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,624,950.00 | 181,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 129,814,189.82 | 171,299,511.60 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **27,505.59** | **7,818,560.95** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,505.59 | 7,818,560.95 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(3,213,042.02)** | **203,406,174.61** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | 0.00 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,213,042.02)** | **203,406,174.61** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/ төгрөгөөр /*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,001,295,500.00** | **2,468,447,906.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **5,173,700.00** | **7,096,506.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 7,096,506.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,173,700.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,981,800.00** | **250,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,481,800.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **261,289,500.00** | **254,851,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 261,289,500.00 | 254,851,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,727,850,500.00** | **2,206,250,400.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,727,850,500.00 | 2,206,250,400.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,914,604,265.93** | **2,286,156,949.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,914,604,265.93** | **2,286,156,949.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,337,889,985.41 | 1,642,997,636.00 |
| 210101 | Үндсэн цалин | 907,176,266.41 | 1,114,541,266.00 |
| 210102 | Нэмэгдэл | 348,012,304.00 | 459,179,581.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,688,000.00 | 31,551,431.00 |
| 210104 | Урамшуулал | 60,013,415.00 | 37,725,358.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **160,384,511.17** | **207,234,419.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,178,053.73 | 140,941,904.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,885,937.00 | 16,581,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,161,239.88 | 13,264,943.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,619,093.84 | 3,283,174.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,540,186.72 | 33,162,898.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **207,236,777.00** | **237,564,339.05** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,567,123.00 | 7,320,567.05 |
| 210302 | Түлш, халаалт | 180,526,500.00 | 190,154,580.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,143,154.00 | 40,089,192.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,421,800.00** | **0.00** |
| 210404 | Ном, хэвлэл | 4,481,800.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 940,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,475,200.00** | **9,468,100.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,475,200.00 | 9,468,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,524,340.00** | **20,400,794.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 622,000.00 | 7,096,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,902,340.00 | 13,304,294.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **56,564,100.00** | **55,276,909.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,588,100.00 | 33,964,709.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,976,000.00 | 21,312,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **129,080,046.76** | **105,396,191.20** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 129,080,046.76 | 105,396,191.20 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **27,505.59** | **7,818,560.95** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,505.59 | 7,818,560.95 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **83,327,460.00** | **63,254,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 83,327,460.00 | 63,254,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **83,327,460.00** | **63,254,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 3,363,774.07 | 119,036,956.11 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 3,363,774.07 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 3,363,774.07 | 122,400,730.18 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **631,596,249.02** | **777,203,112.87** | **468,679,992.46** | **1,877,479,354.35** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **631,596,249.02** | **777,203,112.87** | **468,679,992.46** | **1,877,479,354.35** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **631,596,249.02** | **777,203,112.87** | **468,679,992.46** | **1,877,479,354.35** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 203,406,174.61 | **203,406,174.61** |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **631,596,249.02** | **777,203,112.87** | **672,086,167.07** | **2,080,885,528.96** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/ төгрөгөөр /*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Хувь |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 3,363,774.07 | 0.0 |
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,216,303,700.00** | **2,094,559,943.89** | 208.3 |
| 210 | **Бараа, үйлчилгээний зардал** | **2,086,308,100.00** | **1,989,163,752.69** | 209.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,731,542,800.00 | 1,642,997,636.00 | 257.9 |
| 210101 | Үндсэн цалин | 1,182,842,300.00 | 1,114,541,266.00 | 236.9 |
| 210102 | Нэмэгдэл | 487,645,100.00 | 459,179,581.00 | 307.1 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 0.00 | 31,551,431.00 | 814.1 |
| 210104 | Урамшуулал | 61,055,400.00 | 37,725,358.00 | 287.0 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **216,443,300.00** | **207,234,419.69** | 260.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 147,181,300.00 | 140,941,904.00 | 260.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,315,400.00 | 16,581,500.00 | 260.3 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 13,852,400.00 | 13,264,943.55 | 260.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,463,300.00 | 3,283,174.14 | 257.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,630,900.00 | 33,162,898.00 | 260.3 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **24,011,100.00** | **21,300,794.00** | 299.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,803,000.00 | 7,096,500.00 | 0.0 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 14,208,100.00 | 14,204,294.00 | 199.9 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **114,310,900.00** | **117,630,903.00** | 133.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,353,800.00 | 96,318,703.00 | 124.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,957,100.00 | 21,312,200.00 | 200.0 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **129,995,600.00** | **105,396,191.20** | 183.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 129,995,600.00 | 105,396,191.20 | 183.8 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,206,250,400.00** | **2,206,250,400.00** | 248.8 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,206,250,400.00 | 2,206,250,400.00 | 248.8 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,053,000.00** | **7,346,506.00** | 0.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих | 0.00 | 7,096,506.00 | 0.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагаанаас санхүүжих | 10,053,000.00 | 250,000.00 | 0.0 |

**Аудит хийсэн Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*/ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 254,851,000.00 | 247,032,439.05 | 96.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 254,851,000.00 | 247,032,439.05 | 96.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 245,382,900.00 | 237,564,339.05 | 96.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,000,000.00 | 7,320,567.05 | 73.2 |
| 210302 | Түлш, халаалт | 188,351,000.00 | 190,154,580.00 | 101.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 47,031,900.00 | 40,089,192.00 | 85.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,468,100.00 | 9,468,100.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,468,100.00 | 9,468,100.00 | 100.0 |
| 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | 254,851,000.00 | 254,851,000.00 | 100.0 |
| 12 | Татварын бус орлого | 254,851,000.00 | 254,851,000.00 | 100.0 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 254,851,000.00 | 254,851,000.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Тайлант онд нэмэлт санхүүжилт хийгдээгүй.

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,852.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэн бөгөөд 955.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдааг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

### 5.1.1 Бараа материалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Сургуулийн үдийн хоолны материалын үлдэгдэлд санамсаргүй сонголтод хамруулан тооллого хийж, байвал зохих үлдэгдэлтэй тулган тооцоход сонгино 15.4 кг, үхрийн мах 78.1 кг, аарц 8.9 кг, үнийн дүнгээр нийтдээ 955,180.00 төгрөгийн дутагдал илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “Үнэн зөв байх;” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”-ын Агуулахын бүртгэлд: ... Материал, үнэ бүхий зүйлийн хөдөлгөөнийг эд хариуцагчид "Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт"-ийг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нэгжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлохын хамт тайлант хугацаанд хариуцагч нягтлан бодогчоор тайлангаа хянуулж үлдэгдлийг батлуулан гарын үсэг зуруулна” гэсэн заалтуудыг мөрдлөг болгон ажиллаагүйтэй холбоотой.

Шийдвэрлэсэн: Дутагдуулсан хөрөнгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

### 5.2 Албан шаардлага

1. Шилэн данстай холбоотой

*Илрүүлэлт:*

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд батлагдсан төсвийн хөрөнгийн хүрээнд худалдан авах төлөвлөгөөг боловсруулж байршуулаагүй, 10,801.5 мянган төгрөгийн 6 тушаал орхигдуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журмын 3 дугаар зүйлийн 3.2.10-тай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### 5.3 Зөвлөмж

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой

*Илрүүлэлт:* Хууль тогтоомжийн хэрэглээний ойлголтын зөрүүгээр Хөдөлмөрийн гэрээг алдаатай байгуулснаас өндөр насны тэтгэвэрт гарсан хавсралт дахь нэр бүхий 10 ажилтанд 2023 онд 8-12 сарын хугацаанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 5,930,943.00, ур чадварын нэмэгдэлд 4,164,813.00 нийт 10,095,756.00 төгрөг тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл. Хориглох зүйлийн 31.1.4-т " хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд", Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар зөвлөмжийн 8-д "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн" эсхүл "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн" үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албаны сонгогддогоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно" заалттай нийцэхгүй байгаа нь ангилал ба ойлгомжтой байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн:* Холбогдох эрх зүйн актуудыг сайтар судалж, түүнд нийцүүлэн тушаал шийдвэр гаргах, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

2. Дотоод хяналттай холбоотой

*Илрүүлэлт:*

Бараа материалын тайлан, анхан шатны баримтуудтай танилцахад агуулахын бүртгэл хөтөлдөггүй, зарим баримтын гарын үсгийн баталгаажуулалт дутуу, шинээр карталсан хөрөнгийг тухай бүрт кодлоогүй байсан нь холбогдох журмын зааврыг бүрэн мөрдлөг болгоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих заавар"-ыг мөрдлөг болгоогүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

*Шийдвэрлэсэн:* Агуулахын бүртгэл болон анхан шатны баримтуудыг холбогдох журам, зааврын дагуу бүрэн хөтлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал дутагдсан | 1 | 955.2 | 1 | 955.2 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **955.2** | **1** | **955.2** | - | - | - | - | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн данстай холбоотой | 1 | 10,801.5 | - | - | 1 | 10,801.5 | - | - |
| Хөрөнгөд тавих хяналттай холбоотой | 2 | 10,095.8 | - | - | - | - | 2 | 10,095.8 |
| **Дүн** | **3** | **20,897.3** | **-** | **-** | **1** | **10,801.5** | **2** | **10,095.8** |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |